

ТӨВ АЙМГИЙН БАЯНХАНГАЙ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧИЙН

ХУРЛЫН ТОГТООЛ

2022 оны 2 дугаар сарын 25-ны өдөр

Дугаар 02

Улаанхад

**МАЛЫН ТОО ТОЛГОЙН АЛБАН ТАТВАР ТОГТООХ ТУХАЙ**

Сумын малын тоо толгойн албан татварын хэмжээ тогтоох тухай сумын Засаг дарга С.Баярмаагийн мэдээлэл, өргөн мэдүүлсэн төсөл, түүнд Хурлын Эдийн засаг, төсөв санхүүгийн хорооноос хийсэн дүгнэлтийг хэлэлцээд, Малын тоо толгойн албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.2, 6.3, 6.4, Татварын ерөнхий хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.2 дахь заалт, Монгол Улсын засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх заалтуудыг тус тус үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит бус III хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Малчин, мал бүхий этгээдийн нэг толгой малд ногдуулах албан татварын хэмжээг дор дурдсанаар тогтоосугай.

Үүнд:

Тэмээ 1000 төгрөг

Адуу 1000 төгрөг

Үхэр 600 төгрөг

Хонь 500 төгрөг

Ямаа 500 төгрөг

2. Мал бүхий этгээдийн малын толгой тутамд ногдуулах албан татварын хэмжээг энэ тогтоолын 1-д заасантай адил хэмжээгээр тогтоосугай.

3. Малын тоо толгойн албан татварын тухай хууль, энэ тогтоолыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, малын тоо толгойн албан татварын орлогыг сумын жил бүрийн төсөвт тусган батлуулах, сумын орон нутгийн хөгжлийн санд төвлөрүүлэн Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.2.8-д заасан зориулалтаар зохих журмын дагуу зарцуулахыг сумын Засаг дарга /С.Баярмаа/-д даалгасугай.

4. "Малын тоо толгойн албан татвар тогтоох тухай" тогтоолыг Хууль зүй дотоод хэргийн яаманд хүргүүлэн, захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгүүлэн мөрдүүлэх арга хэмжээ авахыг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга /Д.Батбямба/-д даалгасугай.

5. Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдэд үүрэг болгосугай.

ДАРГА Д.МӨНХБАТ